

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .	8
	2.11. Шилэн дансны мэдээлэл	8
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019. 03. 20 № 06/509
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Монголын цахилгаан холбоо" ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

"Монголын цахилгаан холбоо" ХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Монголын цахилгаан холбоо” Хувьцаат Компани (цаашид “ХК” гэх)-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн захирал М.Алтан-Очир Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Хүлэгтхүмнү аудит” Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани (цаашид “ХХК” гэх)-ийн ахлах аудитор Ё.Наранбилэг, аудитор Ч.Ичинхорол, аудиторовын туслах Ц.Дуламсүрэн, аудиторовын туслах Ц.Өнөрцэцэг, аудиторовын туслах Э.Энхзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Монголын цахилгаан холбоо” ХК нь 2018 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдөр 5а/89 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Монголын цахилгаан холбоо” ХК нь “Харилцаа бүрийг бид холбоно” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Улсын бүртгэлийн гэрчилгээгээр “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутаг, улс, хот хоорондын цахилгаан холбооны ашиглалт, үйлчилгээ
- Монгол Улсын нутаг дэвсгэрт интернетийн үйлчилгээ

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Компанийн тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Монголын цахилгаан холбоо” ХК нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Прософт” програм хангамжийг ашиглан бэлтгэсэн.

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 40 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 40 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд байгууллагын санхүүгийн тайлангийн гол хэрэглэгчид нь Монгол Улсын Засгийн газар болон Үндэсний аудитын газар юм.

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн шатанд нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тайлант жилд нийт орлого 7.8 хувиар буурсан, мөн аудитын асуулгаар интернет үйлчилгээний орлогын данс анхаарал татахуйц байсантай холбоотой юм.

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 2018 оны нийт орлого 21,193.8 сая төгрөг /аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлангийн дүнгээр/ бөгөөд түүний 1 хувь болох 211.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг нийт орлогын суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь дотоод хяналтын орчны эрсдэлийг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 42 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцсоноос 7 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж, 33 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дор хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Авлагын үнэ цэнэ буурсныг илтгэх бодитой нотолгоо /хугацаа хэтэрсэн, хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эзэн холбогдогч нь тодорхойгүй г.м/ байхад авлагын үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь НББОУС 39(63)-д "Хэрэв хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэх бодитой нотолгоо байгаа бол уг гарзын дүнг тухайн хөрөнгийн дансны үнийн ба тухайн хөрөнгийн ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр хэмжинэ" гэж зааснаас гажсан байна.

Шийдвэрлэсэн нь: 2018 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

2. Ирээдүйн үр өгөөжгүй /ашиглах боломжгүй/ болсон 26.6 сая төгрөгийн бараа материалын үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь НББОУС 2(9)-д "Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлнэ" гэж зааснаас гажсан байна.

Шийдвэрлэсэн нь: 2018 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

3. Урьдчилгаа төлбөр нь төлөгдсөн хөрөнгө, үйлчилгээг хүлээн авсан, эсвэл бүр авахааргүй болсон зэрэг шалтгаантай урьдчилж төлсөн зардлыг үл хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна. /12 харилцагчийн 573.7 сая төгрөг нь 1996-2017 оны хооронд болсон үйл явдалтай холбоотой/

Энэ нь СТОУС-ын СҮБ (ЧШ12)-д "Санхүүгийн тайлан нь эдийн засгийн юмс үзэгдлийг үгээр болон тоогоор илэрхийлэн харуулдаг. Санхүүгийн мэдээллийг үр ашигтай болгохын тулд уг мэдээлэлд холбоотой юмс үзэгдлийг илэрхийлэхийн зэрэгцээ харуулах ёстой юмс үзэгдлийг мөн үнэн зөв илэрхийлнэ. Ийм мэдээлэл иж бүрэн, төв голч, алдаагүй байх нь зүйтэй" гэж зааснаас болон стандартын бусад хэд хэдэн заалтаас гажсан байна.

Шийдвэрлэсэн нь: 2018 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

4. Үндсэн хөрөнгийн тодорхойлоход хамаарах хөрөнгө /GPON тоног төхөөрөмж/-ийг бараа материалаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь НББОУС 16(8)2-д "Аж ахуй нэгж нэг ба түүнээс дээш жил ашиглана гэж тооцож байгаа томоохон эд анги болон нөөцөлж буй тоног төхөөрөмжийг зөвхөн үндсэн хөрөнгөтэй холбоотой ашигладаг бол тэдгээрийг мөн үндсэн хөрөнгө гэж бүртгэнэ" гэж зааснаас гажсан байна.

Шийдвэрлэсэн нь: 2018 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

5. 2018 онд худалдан авалт нь хийгдээгүй "Суурин утасны станцуудыг дараа үеийн (NGN) технологид холбох тоног төхөөрөмж"-ийг худалдан авахтай холбоотойгоор урьдчилан төлсөн төлбөр /40,220 доллар/-ийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалд "Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн зардал/тооцоонд хамруулна" гэж зааснаас гажсан байна.

Шийдвэрлэсэн нь: 2018 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

6. Хөрөнгийн шалгуурыг хангаж байгаа 78 байршил дахь 160.3 мянган м.кв талбай бүхий газар эзэмших эрх /бодит үнэ цэнэ нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 8,124.8 сая төгрөг/-ийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь НББОУС 38(21)-д "Хөрөнгөд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай, хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой болсон үед биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө" гэж зааснаас гажсан байна.

Шийдвэрлэсэн нь: 2018 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

7. 2017 онд Жемнет компаниас хүлээн авсан интернет сувгийн түрээсийн 165.3 сая төгрөгийн зардлыг 2018 онд хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Энэ нь НББОУС 1(27)-д "Аж ахуй нэгж нь мөнгөн гүйлгээний мэдээллээс бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь дээр үндэслэн бэлтгэх ёстой" гэж зааснаас гажсан байна.

Шийдвэрлэсэн нь: 2018 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

**Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал**

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	198.2	Дахин үнэлгээ болон авлагын данстай холбоотой асуудлаар зөвлөмж өгсөн.
	Дүн:	2	198.2	

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 142 дугаар хурлын тогтоолоор компанийн 2018 оны бизнесийн зорилтот түвшинг баталсан байна. 2018 оны зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулав.

Үзүүлэлт	2018 оны төлөвлөгөө (сая төгрөг)	2018 оны гүйцэтгэл (сая төгрөг)	Гүйцэтгэл хувиар	Өөрчлөлт дүнгээр (сая төгрөг)
Нийт орлого	22,909.3	21,126.8	92.2%	(1,782.5)
Нийт зардал	22,765.0	20,711.2	91.0%	(2,053.8)
Татварын өмнөх ашиг	144.3	415.6	288.0%	271.3

2018 онд нийт орлого нь төлөвлөгөөнөөс 92.2 хувиар буюу 1,782.5 сая төгрөгөөр, нийт зардал нь төлөвлөгөөнөөс 91.0 хувиар буюу 2,053.8 сая төгрөгөөр тус тус буурч, татварын өмнөх ашиг нь төлөвлөгөөнөөс 288.0 хувиар буюу 271.3 сая төгрөгөөр өссөн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Монголын цахилгаан холбоо” ХК нь “Шилэн дансны тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасны дагуу 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын www.telecommongolian.mn/qacc цахим хуудаснаас Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг шалгахад тус хуулийн 6.8-д заасан зарим мэдээллийг байршуулаагүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 947.9 сая төгрөгийн 4 зөвлөмж өгснийг 2018 онд бүрэн биелүүлэн ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Монголын цахилгаан холбоо" ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байгаа талаар Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Үндсэн хөрөнгийн дараа үеийн хүлээн зөвшөөрөлтийн хэмжилттэй холбоотой асуудлаар

3.1.1 Илрүүлэлт:

Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилтэнд нь дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгүүдэд компани үүсгэн байгуулагдсан 1995 оноос хойш 24 жилийн хугацаанд дахин үнэлгээг огт хийж байгаагүй, 2018 оны санхүүгийн тайланд тэдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр нь илэрхийлээгүй алдааг гаргасан байна.

3.1.2 Эрсдэл:

Дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр тусгаагүйгээс санхүүгийн тайлан нь СТОУС-д нийцэхгүй болох.

3.1.3 Шийдвэрлэсэн нь:

Дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгүүдийг 2019 оны 6 сарын 30-ны өдөр багтан дахин үнэлж санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр тусгах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу:

Холбогдох арга хэмжээг авч 2019 оны санхүүгийн тайланд тусгана.

3.2 Улсын хэмжээнд 150 сумыг шилэн кабелиар холбох төслийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Улсын хэмжээнд 2014-2015 онд Засгийн газрын оролцоотойгоор хэрэгжүүлсэн 150 сумыг шилэн кабелиар холбох төслийн ажилтай холбоотой гэрээ хэлцэл, акт зэрэг баримт байхгүйгээс түүнтэй холбоотойгоор өмнөх онуудад алдаатай хүлээн зөвшөөрч бүртгэгдсэн /5 аймгийн 19 сум/ 253.7 сая төгрөгийн авлага, 66.1 сая төгрөгийн өр төлбөрийн алдааг залруулж чадаагүй.

3.2.2 Эрсдэл:

Дээрх ажил гүйлгээ, үйл явдлын нөлөөгөөр санхүүгийн тайлан СТОУС-д нийцэхгүй болох.

3.2.3 Шийдвэрлэсэн нь:

Ажил гүйлгээ, үйл явдлыг бүртгэхэд шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлэн алдааг 2019 оны санхүүгийн тайланд залруулж бүртгэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу:

Холбогдох арга хэмжээг авч 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,858,621,824.42	2,095,624,485.57
1.1.2	Дансны авлага	3,389,669,193.63	1,573,815,732.93
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	107,848,710.26	13,003,389.43
1.1.4	Бусад авлага	1,490,077,292.77	1,005,143,043.75
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	6,786,316,766.20	5,831,510,348.05
1.1.6	Бараа материал	3,699,988,084.84	2,876,158,667.92
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,135,554,255.45	782,587,816.97
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	18,468,076,127.57	14,117,843,484.62
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	16,815,679,400.19	18,227,108,898.73
1.2.2	Биет бус хөрөнгө	301,454,480.18	8,337,971,012.26
1.2.3	Биологийн хөрөнгө	15,540,000.00	15,810,000.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	137,643,734.47	117,678,798.52
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	17,270,317,614.84	26,698,568,709.51
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	35,738,393,742.41	40,876,412,194.13
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	432,130,733.20	488,325,501.38
2.1.1.2	Цалингийн өглөг	96,336.00	
2.1.1.3	Татварын өр	1,890,071.49	587,971,363.26
2.1.1.4	НДШ–ийн өглөг	653,180.52	
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	147,773,005.89	147,444,688.38
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	430,883,835.71	589,409,827.89
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		

2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,405,174,977.49	1,026,176,690.31
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,418,602,140.3	2,839,328,071.22
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	4,370,849,753.20	4,370,849,753.20
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,370,849,753.2	4,370,849,753.2
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,789,451,893.5	7,210,177,824.42
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,414,360,453.00	2,449,928,700.00
2.3.2	- хувийн	1,172,667,136.00	137,098,889.00
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	117,678,676.46	8,242,516,167.46
2.3.9	Хуримтлагдсан ашиг	26,244,235,583.45	22,836,690,613.25
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	28,948,941,848.91	33,666,234,369.71
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	35,738,393,742.41	40,876,412,194.13

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	20,681,687,374.06	18,919,783,613.37
2	Борлуулалтын өртөг	17,817,945,300.96	17,026,321,983.14
3	Нийт ашиг(алдагдал)	2,863,742,073.10	1,893,461,630.23
4	Түрээсийн орлого		903,407,941.76
5	Хүүгийн орлого	1,018,069,717.71	992,887,698.48
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	15,225,537.87	264,844,827.46
9	Борлуулалт, маркетингийн зардал	421,629,966.94	510,490,683.06
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,438,344,261.96	2,534,297,296.28
11	Санхүүгийн зардал		-
12	Бусад зардал	887,393,560.65	586,314,088.53
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(82,290,809.41)	45,866,300.50
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	40,434,572.72	(27,248,035.16)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		-
17	Бусад ашиг (алдагдал)		(26,550,500.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	107,813,302.44	415,567,795.4
19	Орлогын татварын зардал	101,806,971.79	99,549,386.85
20	Татварын дараах ашиг (алдагдал)	6,006,330.65	316,018,408.55
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	6,006,330.65	316,018,408.55
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	6,006,330.65	316,018,408.55
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	6,006,330.65	316,048,408.55

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	21,075,879,015.55	21,051,083,705.13
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	20,264,947,181.59	20,494,925,124.10
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		2,666,663.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		-
1.1.6	Бусад мөнгөн орлого	810,931,833.96	553,491,918.03
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,672,156,396.20	18,045,208,358.44
1.2.1	Ажиллагчдад төлсөн	5,415,366,972.06	5,202,209,732.72
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,329,393,315.55	1,395,327,639.06
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,536,438,145.02	1,318,948,172.69
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	8,367,127,271.96	6,601,823,721.89
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	268,166,612.85	321,316,941.48
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	65,826.09	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,680,168,173.03	1,458,945,736.11
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	10,913,351.00	17,177,865.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,064,648,380.82	1,729,458,549.49
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	403,722,619.35	3,005,875,346.69
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,108,481,989.74	121,627,399.03
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	43,718,030.00	18,394,697.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	340,000.00	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		10,126,473.34
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,064,423,959.74	93,106,228.69
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		-
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,606,564,629.96	4,166,457,658.25
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,606,564,629.96	4,166,457,658.25
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		

2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,498,082,640.22)	(4,044,830,259.22)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	1,256,454,071.16
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.1.3	Төрөл бүрийн хандив		-
3.1.4	Бусад орлого		1,256,454,071.16
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,207,979,335.78	4,978,516.92
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	81,651.78	300,998.12
3.2.4	Төлсөн ногдол ашиг	1,207,897,684.00	4,677,518.80
3.2.5	Бусад зарлага		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,207,979,335.78)	1,251,475,554.24
4	Валютын ханшийн зөрүү	24,578,751.15	24,482,019.44
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,326,918,107.8)	237,002,661.15
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,185,539,932.22	1,858,621,824.42
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,858,621,824.42	2,095,624,485.57

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	2,587,027,589.00					117,678,676.46	26,238,229,252.80	28,942,935,518.26
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл	2,587,027,589.00					117,678,676.46	26,238,229,252.80	28,942,935,518.26
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							6,006,330.65	6,006,330.65
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00					117,678,676.46	26,244,235,583.45	28,948,941,848.91
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(3,723,563,378.75)	(3,723,563,378.75)
11	Залруулсан үлдэгдэл	2,587,027,589.00					117,678,676.46	22,520,672,204.70	25,225,378,470.16
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							316,018,408.55	316,018,408.55
13	Бусад дэлгэрэнгүй орлого						8,124,837,491.00		8,124,837,491.00
14	Өмчид гарсан өөрчлөлт								
15	Зарласан ногдол ашиг								
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
17	2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00					8,242,516,167.46	22,836,690,613.25	33,666,234,369.71

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын хураангуй тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018.03.15	Аудитын нэр:	"Монголын цахилгаан холбоо" ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/78/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	"Монголын цахилгаан холбоо" ХК			сая төгрөгөөр	

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	8	9
1	Балансын данстай холбоотой асуудал	1	Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилтэнд нь дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгүүдэд компани үүсгэн байгуулагдсан 1995 оноос хойш 24 жилийн хугацаанд дахин үнэлгээг огт хийж байгаагүй, 2018 оны санхүүгийн тайланд тэдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр нь илэрхийлээгүй.	-	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал	М.Алтан-Очир
2	Балансын данстай холбоотой асуудал	1	Улсын хэмжээнд 2014-2015 онд Засгийн газрын оролцоотойгоор хэрэгжүүлсэн 150 сумыг шилэн кабелиар холбох төслийн ажилтай холбоотой гэрээ хэлцэл, акт зэрэг баримт байхгүйгээс түүнтэй холбоотойгоор өмнөх онуудад алдаатай хүлээн зөвшөөрч бүртгэгдсэн /5 аймгийн 19 сум/ 253.7 сая төгрөгийн авлага, 66.1 сая төгрөгийн өр төлбөрийн алдааг залруулж чадаагүй.	187.60	Зөвлөмж	Аймгуудын Холбооны газрын дарга нар	
			Дүн	187.60			

Бэлтгэсэн: Аудитор

Ё.Наранбилэг

Анхан шатанд хянасан: ЧХ-ын менежер

Е.Оюундэлгэр

